

МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Ангиллын код

Тохирлын үнэлгээ - Менежментийн тогтолцооны аудит болон баталгаажуулалтыг гүйцэтгэх байгууллагад тавих шаардлага - 9-р хэсэг: Авлигын эсрэг менежментийн тогтолцооны аудит болон баталгаажуулалтад тавих чадавхын шаардлага	MNS ISO/IEC TS 17021-9:2024
Conformity assessment — Requirements for bodies providing audit and certification of management systems — Part 9: Competence requirements for auditing and certification of antibribery management systems	ISO/IEC TS 17021-9:2016

Стандарт, хэмжил зүйн газрын даргын оны дугаар сарын ... -ны өдрийн дугаар тушаалаар батлав.

Энэ стандартыг оны дугаар сарын ... -ны өдрөөс эхлэн мөрдөнө.

1 Хамрах хүрээ

Энэхүү стандарт нь авлигын эсрэг менежментийн тогтолцоо (АЭМТ)-ны аудит болон баталгаажуулалтын үйл явцад оролцох ажилтны чадавхад тавих нэмэлт шаардлагыг тогтоох бөгөөд ISO/IEC 17021-1 стандартын хавсралт болно.

2 Норматив эшлэл

Энэхүү стандартад дараах баримт бичгийг бүхлээр нь эсхүл хэсэгчлэн эш татсан бөгөөд энэхүү стандартыг хэрэглэхэд салшгүй хэсэг нь байна. Огноо заасан эшлэлийн хувьд зөвхөн тухайн хэвлэлийг хэрэглэнэ. Огноо заагаагүй эшлэлийн хувьд эш татсан баримт бичгийн хамгийн сүүлийн хэвлэл (аливаа нэмэлт өөрчлөлтийн хамт)-ийг хэрэглэнэ.

ISO/IEC 17021-1:2015, Тохирлын үнэлгээ — Менежментийн тогтолцооны аудит болон баталгаажуулалтыг гүйцэтгэх байгууллагад тавих шаардлага. 1-р хэсэг: Шаардлага

ISO 37001:2016, Авлигын эсрэг менежментийн тогтолцоо – Шаардлага ба хэрэглэх зааварчилгаа

3 Нэр томъёо, тодорхойлолт

Энэхүү баримт бичигт ISO 37001 болон ISO/ICE 17021-1 стандартад заасан нэр томъёог хэрэглэнэ.

ОУСБ (ISO) ба ОУЦТК (IEC) нь стандартчилалд ашиглах нэр томъёоны өгөгдлийн санг эрхлэн хариуцах ба дараах хаягаар дамжуулан хүргэж байна:

- ОУСБ (ISO)-ын цахим хайлтын талбар: www.iso.org/obp
- ОУЦТК (IEC)-ын цахим лавлах: www.electropedia.org

4 Ерөнхий чадавхын шаардлага

Баталгаажуулалтын байгууллага нь ISO/IEC 17021-1 стандартын А.1 хүснэгтэд заасны дагуу баталгаажуулалтын чиг үүрэг тус бүрийн чадавхын шаардлагыг тодорхойлно. Баталгаажуулалтын байгууллага нь эдгээр чадавхын шаардлагыг тодорхойлохдоо ISO/IEC 17021-1 стандарт, холбогдох 5, 6-р бүлэгт заасан бүх шаардлагыг авч үзнэ.

1-Р ТАЙЛБАР: А хавсралтад тодорхой баталгаажуулалтын чиг үүрэгт оролцох ажилтанд тавих чадамжийн шаардлагыг тусгасан болно.

2-Р ТАЙЛБАР: Аудитын зарчмын талаарх мэдээллийг ISO 19011 стандартад тусгасан болно.

5 Авлигын эсрэг менежментийн тогтолцоо (АЭМТ)-ны аудитын багт тавих чадавхын шаардлага

5.1 Ерөнхий зүйл

АЭМТ-ны аудитын багт оролцох бүх ажилтан нь ISO/IEC 17021-1-д заасан ерөнхий чадавх, ISO 37001 стандартын шаардлага болон тэдгээр шаардлагуудын уялдаа холбооны талаарх ойлголттой, 5.2-өөс 5.8-д заасан АЭМТ-ны мэдлэг, чадавхын түвшинтэй байна.

ТАЙЛБАР: Аудитын багийн аудитор бүр нэг ижил чадавхтай байх шаардлагагүй боловч аудитын багийн хамтын чадавх нь аудитын зорилтыг хэрэгжүүлэхэд хангалттай байх хэрэгтэй.

5.2 Авлигын тухай ойлголт

5.2.1 Аудитын баг нь хамгийн багадаа дараах зүйлсийг багтаасан авлигын тухай мэдлэгтэй байна. Үүнд:

- а) шууд болон шууд бус төлбөр;
- б) хөнгөвчлөх төлбөр;
- в) санхүүгийн бус ашиг тус буюу давуу тал (тухайлбал, гэр бүлийн гишүүдэд ашиг тустай, боломж олгох гэх мэт);
- г) ашиг сонирхлын зөрчил.

5.2.2 Аудитын баг нь нийтийн албан тушаалтан, агент, зөвлөх, туслан гүйцэтгэгч, гэр бүл эсхүл хамаарал бүхий этгээд зэрэг гуравдагч талтай холбоотой авлигын эрсдэлийн талаар мэдлэгтэй байна.

5.2.3 Аудитын баг нь хамгийн багадаа дараах зүйлсэд хамаарах авлигын тохиолдлын талаар мэдлэгтэй байна. Үүнд:

- a) ажилтан, ажилд авах, томилох үйл явц болон цалин урамшуулал;
- b) худалдааны үйл ажиллагаа;
- c) аялал, бэлэг болон зочлол хүндэтгэл;
- d) хандив болон ивээн тэтгэлэг;
- e) худалдан авах, гэрээ байгуулах ажиллагаа;
- f) борлуулалт, маркетинг;
- g) үйлдвэрлэл, нийлүүлэлтийн сүлжээ;
- h) бусдаар гүйцэтгүүлэх үйл явц;
- i) компанийг нэгтгэх болон худалдан авах ажиллагаа.

5.2.4 Аудитын баг нь авлигын үзүүлэлтүүд (анхаарах асуудлууд)-ийн талаар мэдлэгтэй байна.

ТАЙЛБАР: Авлигын үзүүлэлтүүд (анхаарах асуудлууд)-ийн жагсаалтын талаар Олон улсын худалдааны танхим (ОУХТ), Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (ЭЗХАХБ) болон Дэлхийн банк (ДБ) зэрэг эх сурвалжаас танилцаж болно.

5.2.5 Аудитын баг нь авлигаас урьдчилан сэргийлэх, илрүүлэх, хариу арга хэмжээ авахад хэрэглэгдэх хяналт болон түүнийг зохих ёсоор хэрэгжүүлээгүй эсхүл орхигдуулснаас үүсэх үр дагаврын талаар мэдлэгтэй байна.

5.3 Байгууллагын төлөв байдал

5.3.1 Аудитын баг нь ISO 37001:2016 стандартын 4-р бүлэг, байгууллагын үйл ажиллагааны төлөв байдлын талаар мэдлэгтэй байна.

5.3.2 Аудитын баг нь байгууллагатай холбоотой сүүлийн үеийн авлигын асуудал, баримт, салбартай холбоотой авлигын эрсдэл эсхүл төрийн байгууллагатай явуулах харилцаа буюу зохицуулалтын түвшин зэргийг тодорхойлж, ойлгохын тулд бие даасан судалгаа хийхэд шаардлагатай мэдлэг, ур чадвартай байна.

5.3.3 Аудитын баг нь компанийн бүтэц, тухайлбал, компанийг худалдан авах ажиллагаа буюу нэгтгэл, хамтарсан үйлдвэрлэл үйлчилгээ болон хөрөнгө оруулалтын арга хэлбэрүүдийн талаар мэдлэгтэй байна.

5.4 Хууль тогтоомж, зохицуулалт болон бусад шаардлага

Аудитын баг нь холбогдох хуулийн шаардлага болон тухайн байгууллагын авлигын эсрэг менежментийн тогтолцоонд хамаарах бусад шаардлагад нийцэж байгааг тодорхойлох, үнэлэхэд зориулсан байгууллагын журам нь хангалттай бөгөөд хэрэгжсэн эсэхийг олж тогтоох мэдлэгтэй байна.

5.5 Авлигын эрсдэлийн үнэлгээ ба магадлан шалгалт

Аудитын баг нь магадлан шалгалт (ISO 37001:2016-ын 8.2), бизнесийн хамаарал бүхий талтай холбоотой авлигын эрсдэл (ISO 37001:2016-ын 8.5) зэрэг олон төрлийн

аргачлал, тэдгээрт хамаарах сул тал болон асуудлуудын талаарх ойлголтыг багтаасан авлигын эрсдэлийн үнэлгээг ISO 37001:2016 стандартын 4.5-ын дагуу хэрхэн хийдэг талаар мэдлэгтэй байна.

5.6 Авлигын эрсдэл

Аудитын баг нь ISO 37001:2016-ын 7 болон 8 дугаар бүлэгт заасан авлигын эрсдэлийг үнэлэх, түүнд хяналт тавих аргачлал, шаардагдах ур чадварын талаар мэдлэгтэй байна.

5.7 Авлигын эсрэг хяналт

Аудитын баг нь авлигын эсрэг хяналтыг бий болгох, үнэлэх болон авлигыг хянан шалгах талаар мэдлэг, ур чадвартай байна.

5.8 Авлигын эсрэг менежментийн тогтолцоо (АЭМТ)

Аудитын баг нь АЭМТ эсхүл түүнтэй ижил нийцлийн менежмент эсхүл дотоод хяналтын тогтолцоог бий болгох, хэрэгжүүлэх талаар мэдлэг, ур чадвартай байна.

6 Өргөдөл, аудитын тайланд дүн шинжилгээ хийх ба баталгаажуулалтын шийдвэр гаргах зэрэг бусад ажилтнуудад тавих чадавхын шаардлага

6.1 Ерөнхий зүйл

Бусад ажилтнууд нь ISO/IEC 17021-1 стандартад заасан ерөнхий чадавхтай байх ба ISO 37001 стандартын шаардлага болон тэдгээр шаардлагуудын уялдаа холбооны талаарх ойлголт, 6.2 болон 6.3-т заасан АЭМТ-ны мэдлэгийн шаардлагыг хангасан байна.

6.2 Авлигын тухай

Бусад ажилтнууд нь авлигын тухай ойлголт болон эрсдэлийн талаар мэдлэгтэй байна.

6.3 Байгууллагын төлөв байдал

Бусад ажилтнууд нь ISO 37001:2016 стандартын 4-р бүлэг, мөн байгууллагын үйл ажиллагааны төлөв байдлын талаар мэдлэгтэй байна.

А хавсралт
(мэдээллийн)

АЭМТ-ны аудит болон баталгаажуулалтын талаарх мэдлэг

А.1 хүснэгт нь АЭМТ-ны аудит ба баталгаажуулалтад шаардлагатай мэдлэгийг нэгтгэсэн байдлаар харуулсан бөгөөд энэ нь зөвхөн баталгаажуулалтын тусгай чиг үүргийн мэдлэгийн хүрээг тодорхойлох учраас мэдээллийн шинжтэй болно. 4, 5 ба 6-р бүлэг болон А.1 хүснэгтэд заасан ажиллагаа тус бүрд тавих чадавхын шаардлага нь тусгай шаардлагын эш таталтыг заана.

А.1 хүснэгт – АЭМТ-ны аудит ба баталгаажуулалтад хамаарах мэдлэг

Мэдлэг	Баталгаажуулалтын чиг үүрэг		
	Аудитын багт шаардагдах чадавхыг тодорхойлох зорилгоор өргөдөлд дүн шинжилгээ хийх, аудитын багийн гишүүдийг сонгох болон аудитын хугацааг тогтоох	Аудитын тайланд дүн шинжилгээ хийх болон баталгаажуулалтын шийдвэр гаргах	Аудитын баг
Ерөнхий зүйл	6.1	6.1	5.1
Авлигын тухай ойлголт	6.2	6.2	5.2
Байгууллагын төлөв байдал	6.3	6.3	5.3
Хууль тогтоомж, зохицуулалт болон бусад шаардлага	-	-	5.4
Авлигын эрсдэлийн үнэлгээ ба магадлан шалгалт	-	-	5.5
Авлигын эрсдэл	-	-	5.6
Авлигын эсрэг хяналт	-	-	5.7
Авлигын эсрэг менежментийн тогтолцоо (АЭМТ)	-	-	5.8

Ном зүй

- [1] ISO 19011, Менежментийн тогтолцооны аудитын арга зүйн заавар
- [2] ISO 19600, Нийцлийн менежментийн тогтолцоо – Арга зүйн заавар
- [3] ISO 31000, Эрсдэлийн менежмент – Зарчим ба арга зүйн заавар
- [4] Дотоод хяналт, ёс зүй болон нийцлийн тухай зохистой дадлын зааварчилгаа, ЭЗХАХБ
- [5] Олон улсын бизнесийн хэлцэл дэх гадаадын нийтийн албан тушаалтны хахуулийн гэмт хэрэгтэй үргэлжлүүлэн тэмцэх тухай Зөвлөлөөс гаргасан зөвлөмж (2009 он), Хавсралт 1, Олон улсын бизнесийн хэлцэл дэх гадаадын нийтийн албан тушаалтны хахуулийн гэмт хэрэгтэй тэмцэх тухай конвенцын тодорхой зүйл, хэсгийг хэрэгжүүлэх тухай сайн туршлагын зааварчилгаа, мөн Хавсралт 2, Дотоод хяналт, ёс зүй болон нийцлийн тухай сайн туршлагын зааварчилгаа, ЭЗХАХБ
- [6] Менежментийн тогтолцооны стандартуудыг нэгтгэн хэрэглэх нь, ISO гарын авлага